

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/230-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2023 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-15
4. Аудитын тайлан	16-17
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16-17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШЕЗ	Шүүхийн Ерөнхий зөвлөл



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023-02-17 № 09А-2023/230-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мандал сум дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 97.2 хувьтай тайлагнагдсан бөгөөд цалин хөлс, нэмэгдэл, урамшлын зардлыг 0.4 хувиар, НДШ-ийн зардлыг 0.5 хувиар, тогтмол зардлыг 9.6 хувиар, хангамж, бараа материалын зардлыг 21.5 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж нийт төсөв 2.8 хувиар хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Мандал сум дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 85.8 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос

018020047

төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 34,669.9 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 29,160.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 20,455.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА




2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>22,763,746.00</u>	<u>29,343,157.25</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	1,000,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	1,000,000.00
3121	Төгрөг	00.00	1,000,000.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	1,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	22,763,746.00	28,343,157.25
354	Хангамжийн материал	22,763,746.00	28,343,157.25
35410	Бичиг хэргийн материал	2,959,212.00	1,886,164.00
35420	Аж ахуйн материал	19,507,185.00	25,135,556.25
35440	Түлш, шатах тослох материал	297,349.00	1,321,437.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>717,684,468.10</u>	<u>730,121,967.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	717,684,468.10	730,121,967.97
392	Биет хөрөнгө	653,660,718.15	666,223,218.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	595,724,204.08	595,724,204.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-46,623,350.16	-62,164,466.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	154,495,000.00	116,495,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-95,078,333.35	-25,278,333.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	180,830,315.89	148,879,925.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	-149,330,469.72	-118,892,574.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,739,255.00	52,250,199.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,851,336.74	-44,299,183.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,810,058.07	4,810,058.07
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,310,956.92	-1,747,942.56
39217	Ном	256,332.00	446,332.00
393	Биет бус хөрөнгө	64,023,749.95	63,898,749.91
39301	Програм хангамж	1,050,000.00	1,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-706,250.05	-831,250.09
39303	Бусад биет бус хөрөнгө	63,680,000.00	63,680,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>740,448,214.10</u>	<u>759,465,125.22</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>740,448,214.10</u>	<u>759,465,125.22</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	740,448,214.10	759,465,125.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	178,942,622.54	178,942,622.54
51101	Өмч: - төрийн	178,942,622.54	178,942,622.54
512	Хуримтлагдсан үр дүн	-72,870,431.48	-53,853,520.36
51210	Өмнөх үеийн үр дүн	-72,870,431.48	-72,870,431.48
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	19,016,911.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	634,376,023.04	634,376,023.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>740,448,214.10</u>	<u>759,465,125.22</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан



Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	613,135,415.00	728,461,017.25
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,657,715.00	48,358,717.25
120	Нийтлэг татварын бус орлого	74,657,715.00	45,495,279.00
120009	Бусад орлого	509,200.00	38,779,749.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	73,876,419.00	4,701,210.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	272,096.00	2,014,320.00
122	Тусламжийн орлого	00.00	2,863,438.25
122002	Хандив тусламж /гадаад/	00.00	2,863,438.25
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	538,477,700.00	680,102,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	538,477,700.00	680,102,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	538,477,700.00	680,102,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	572,181,321.46	709,426,229.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	572,181,321.46	709,426,229.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	556,127,055.48	690,367,391.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	386,163,000.29	504,015,432.01
210101	Үндсэн цалин	312,014,872.92	335,426,129.80
210102	Нэмэгдэл	47,019,246.79	133,705,199.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,783,873.58	12,329,375.00
210104	Урамшуулал	14,345,007.00	22,554,728.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,206,526.73	63,058,792.00
210201	Тэтгэврийн даатгал	34,812,135.21	42,879,982.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,870,654.88	5,044,702.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,073,003.77	4,035,761.00
210204	Ажилгүйдлийн даатгал	768,221.11	1,008,940.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,682,511.76	10,089,407.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,980,670.00	34,699,968.00
210301	Гэрэл, цахилгаан	4,616,272.00	4,158,145.00
210302	Түлш, халаалт	25,077,144.00	28,659,479.00
210303	Цэвэр, бохир ус	647,254.00	1,882,344.00
210304	Байрны түрээс	5,640,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	33,398,949.00	28,599,649.00
210401	Бичиг хэрэг	9,047,478.00	11,631,548.00
210402	Тээвэр, шатахуун	10,125,651.00	8,205,661.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,883,739.00	5,814,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,011,800.00	190,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,330,281.00	2,758,300.00
	Норматив зардал	500,000.00	

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,507,050.00	18,538,470.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	445,000.00	560,000.00
210604	Урсгал засвар	12,062,050.00	17,978,470.00
2107	Томилолт, зочны зардал	3,676,000.00	3,745,600.00
210702	Дотоод албан томилолт	3,676,000.00	3,745,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,021,763.00	4,907,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,054,500.00	2,030,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,754,700.00	2,678,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,863.00	136,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	63,700.00	18,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,673,096.46	32,801,820.05
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,673,096.46	32,801,820.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,054,265.98	19,058,837.99
	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамгуулал	1,000,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,054,265.98	19,058,837.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,054,265.98	19,058,837.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>40,954,093.54</u>	<u>19,034,788.20</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	17,877.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	17,877.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-17,877.08
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>40,954,093.54</u>	<u>19,016,911.12</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>538,477,700.00</u>	<u>681,102,300.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,000,000.00
120009	Бусад орлого	00.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	538,477,700.00	680,102,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	538,477,700.00	680,102,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	538,477,700.00	680,102,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>533,377,700.00</u>	<u>680,102,300.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	533,377,700.00	680,102,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	517,323,434.02	661,043,462.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	386,163,000.29	504,015,432.01

210101	Үндсэн цалин	312,014,872.92	335,426,129.80
210102	Нэмэгдэл	47,019,246.79	133,705,199.21
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,783,873.58	12,329,375.00
210104	Урамшуулал	14,345,007.00	22,554,728.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,206,526.73	63,058,792.00
210201	Тэтгэврийн даатгал	34,812,135.21	42,879,982.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,870,654.88	5,044,702.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,073,003.77	4,035,761.00
210204	Ажилгүйдлийн даатгал	768,221.11	1,008,940.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,682,511.76	10,089,407.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,980,670.00	34,699,968.00
210301	Гэрэл, цахилгаан	4,616,272.00	4,158,145.00
210302	Түлш, халаалт	25,077,144.00	28,659,479.00
210303	Цэвэр, бохир ус	647,254.00	1,882,344.00
210304	Байрны түрээс	5,640,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	22,376,224.00	29,160,040.00
210401	Бичиг хэрэг	7,354,000.00	10,558,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,980,000.00	8,450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,883,739.00	5,814,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,011,800.00	190,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,146,685.00	4,147,400.00
	Норматив зардал	500,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,399,250.00	20,455,970.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,220,000.00	2,477,500.00
210604	Урсгал засвар	12,179,250.00	17,978,470.00
2107	Томилолт, зочны зардал	3,676,000.00	3,745,600.00
210702	Дотоод албан томилолт	3,676,000.00	3,745,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,021,763.00	4,907,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,054,500.00	2,030,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,754,700.00	2,678,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,863.00	136,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	63,700.00	18,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,054,265.98	19,058,837.99
	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,000,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,054,265.98	19,058,837.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,054,265.98	19,058,837.99

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,100,000.00</u>	<u>1,000,000.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>5,100,000.00</u>	-
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>5,100,000.00</u>	-
	Дотоод эх үүсвэр	<u>5,100,000.00</u>	-
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	<u>5,100,000.00</u>	-
	ХӨРӨНГӨ ООУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ 6=5-4	<u>-5,100,000.00</u>	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	1,000,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	1,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	178,942,622.54	634,376,023.04	-113,824,525.02	699,494,120.56
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	178,942,622.54	634,376,023.04	-113,824,525.02	699,494,120.56
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-40,954,093.54	-40,954,093.54
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	178,942,622.54	634,376,023.04	-72,870,431.48	740,448,214.10
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	178,942,622.54	634,376,023.04	-72,870,431.48	740,448,214.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	178,942,622.54	634,376,023.04	-72,870,431.48	740,448,214.10

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	19,016,911.12	19,016,911.12
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	178,942,622.54	634,376,023.04	-53,853,520.36	759,465,125.22

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	681,102,300.00	661,043,462.01	20,058,837.99	97.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	681,102,300.00	661,043,462.01	20,058,837.99	97.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	680,102,300.00	661,043,462.01	19,058,837.99	97.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,958,000.00	504,015,432.01	2,942,567.99	99.42
210101	Үндсэн цалин	341,262,000.00	335,426,129.80	5,835,870.20	98.29
210102	Нэмэгдэл	134,186,800.00	133,705,199.21	481,600.79	99.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,146,000.00	12,329,375.00	3,816,625.00	76.36
210104	Урамшуулал	15,363,200.00	22,554,728.00	-7,191,528.00	146.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,369,800.00	63,058,792.00	311,008.00	99.51
210201	Тэтгэврийн даатгал	43,091,400.00	42,879,982.00	211,418.00	99.51
210202	Тэтгэмжийн даатгал	5,069,600.00	5,044,702.00	24,898.00	99.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,055,700.00	4,035,761.00	19,939.00	99.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,013,900.00	1,008,940.00	4,960.00	99.51
210205	Эрүүл мэндийн даатгал	10,139,200.00	10,089,407.00	49,793.00	99.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,400,000.00	34,699,968.00	3,700,032.00	90.36
210301	Гэрэл, цахилгаан	3,800,000.00	4,158,145.00	-358,145.00	109.42
210302	Түлш, халаалт	25,600,000.00	28,659,479.00	-3,059,479.00	111.95
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	1,882,344.00	1,117,656.00	62.74
210304	Байрны түрээс	6,000,000.00	00.00	6,000,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	37,151,600.00	29,160,040.00	7,991,560.00	78.49
210401	Бичиг хэрэг	11,500,000.00	10,558,500.00	941,500.00	91.81
210402	Тээвэр, шатахуун	8,579,400.00	8,450,000.00	129,400.00	98.49
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,362,200.00	5,814,140.00	4,548,060.00	56.11
210404	Ном, хэвлэл	600,000.00	00.00	600,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	960,000.00	190,000.00	770,000.00	19.79
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,150,000.00	4,147,400.00	1,002,600.00	80.53
2105	Нормативт зардал	500,000.00	00.00	500,000.00	-

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	00.00	500,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,500,000.00	20,455,970.00	44,030.00	99.79
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,477,500.00	22,500.00	99.10
210604	Урсгал засвар	18,000,000.00	17,978,470.00	21,530.00	99.88
2107	Томилолт, зочны зардал	3,797,300.00	3,745,600.00	51,700.00	98.64
210702	Дотоод албан томилолт	3,797,300.00	3,745,600.00	51,700.00	98.64
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,425,600.00	4,907,660.00	3,517,940.00	58.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,500,000.00	2,030,000.00	3,470,000.00	36.91
210803	Даатгалын үйлчилгээ	2,678,000.00	2,678,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	184,800.00	136,860.00	47,940.00	74.06
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	18,800.00	18,800.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1000000.00	1000000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1000000.00	0.00	1,000,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	00.00	1,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	00.00	1,000,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	681,102,300.00	661,043,462.01	20,058,837.99	97.05
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	681,102,300.00	661,043,462.01	20,058,837.99	97.05
131001	Улсын төсвөөс санхүүжих	681,102,300.00	661,043,462.01	20,058,837.99	97.05
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0	100.00
610001	Төсвийн байгууллага	2	2	0	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	0	100.00
620001	Удирдах ажилтан	2	2	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17	0	100.00
620003	Үйлчлэх ажилтан	4	4	0	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	23	0	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	0	100.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	4	4	0	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10	0	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн тамгын газар / Мандал сум дахь Шүүхийн тамгын газар / нь "Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй хэрэгжүүлэх, нөхцөлийг бүрдүүлж, шүүхийн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй хүргэх" гэсэн эрхэм зорилгыг тавьж ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, хамгаалах,
- Шүүхийн зохион байгуулалт, захиргаа, хүний нөөцийг удирдах,
- Төсвийг төлөвлөх, санхүү, дэд бүтцийг удирдах,
- Шүүгчдийг мэдээллээр хангах, олон нийттэй харилцах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Шүүхийн тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 12 дугаар сарын 23-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 193 дугаар тогтоолоор шүүгчийн туслах болон шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Мандал сум дахь Шүүхийн тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ШЕЗ-ийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанаас хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд дотоод хяналт шалгалт, аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сум дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ШЕЗ-ийн даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 174 дүгээр тушаалаар ШЕЗ-ийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сум дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,016.9 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1,000.00	1,000.00
Авлага	-	-	-
Бараа материал	22,763.70	28,343.20	5,579.50
Үндсэн хөрөнгө	717,684.50	730,121.90	12,437.40
Нийт хөрөнгө	740,448.20	759,465.10	19,016.9
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	740,448.20	759,465.10	19,016.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	740,448.20	759,465.10	19,016.90

Мөнгөн хөрөнгө данс 1,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь ШЕЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу "Ахмадын сан" байгуулж, 100130405501 тоот дансанд байршуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 28,343.2 мянган төгрөг болж 5,579.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 42,460.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, ШЕЗ-өөс 2,014.3 мянган төгрөгийн, бусад шүүхийн байгууллагаас 779.7 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн, ДЗОУБ-аас 307.5 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр тус тус орлого авч, 39,932.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл *ланхны өртгөөр* 983,335.7 мянган төгрөг болж, 77,249.4 мянган төгрөгөөр буурсан нь 4,701.2 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг ШЕЗ-өөс, 2,556.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг ДЗОУБ-аас хүлээн авсан, ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглах боломжтой 76,000.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг 38,000.0 мянган төгрөгээр үнэлж орлого авсан болон ТӨБЗГ-ын даргын 2022 оны 622 дугаар тушаалаар 46,506.6 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг акталж, данс бүртгэлээс хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 759,465.1 мянган төгрөг болж 19,016.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 866,863.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 171,116.9 мянган төгрөгөөр бууруулж *Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 81,728.6 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 89,555.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 16,838.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 39,912.9 мянган төгрөгөөр өсгөсөн нь голлон нөлөөлсөн байна.* 695,746.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг нийт 15,644.1 мянган төгрөгөөр бууруулж төсвийн зохицуулалт хийсэн байна. Үүнд:

- *Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 42,565.1 мянган төгрөгөөр бууруулж,*
- *Цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 10,537.6 мянган төгрөгөөр,*

- Эд хогшил, урсгал засварын зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 5,383.4 мянган төгрөгөөр,
- Бараа, үйлчилгээний бусад зардлыг 1,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 681,102.3 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 680,102.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.



Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 661,043.5 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 19,058.8 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	675,602.30	660,013.50	15,588.80	97.69
2	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	3,500.00	1,030.00	2,470.00	29.43
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,000.00	0.00	1,000.00	-
4	Шинжээч, орчуулагч, хэлмэрчийн зардал	1,000.00	0.00	1,000.00	-
	Дүн	681,102.30	661,043.50	20,058.80	97.05

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130405401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мандал сум дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд өхийсөн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгохгүй байх зөвлөмж өгөгдлөө.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сум дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.


Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 572,181.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,721.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ШЕЗ-ийн даргын 2022 оны 109 дүгээр “Төрийн хэмнэлтийн арга хэмжээний тухай” албан бичгийн дагуу дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж, бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг хэмнэсэн,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Байгууллагын цэвэр, бохир усны зардлыг хэмнэж ажилласан,

Худалдан авах бараа материалын төсвийг хийж, байгууллагын даргаар хянуулан нэн шаардлагатай, зайлшгүй хэрэгцээт материалыг худалдаж авч зарцуулан, төсвийг зохистой удирдаж өр төлбөргүй тайлагнагдсан байна.



4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мандал сум дахь Шүүхийн тамгын газрын мэдээлбэл зохих 20 төрлийн 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэсэн болон худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй зэрэг 2 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлдсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэл		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	4,344.3	2	4,344.3	100
Нийт дүн	2	4,344.3	2	4,344.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,595.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд зөвлөмж хүргүүлээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн албан хаагчийн урамшуулал давхардуулан олгосонтой холбоотой асуудал:

Илрүүлэлт: Нягтлан бодогч Л.Сансугарын ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгосон боловч ШЕЗ-ийн даргын 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 187 дугаар тушаалаар 2021 оны ажлыг "Хангалттай" үнэлүүлсэн гэх үндэслэлээр 2 сарын үндсэн цалинтай тэнцэх 1,595.3 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3: "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг үр дүн, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, нэг ажлын үр дүнгээр урамшууллыг давхардуулан олгохгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл



Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс					
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон.	1	1,595.3					1	1,595.3				
Дүн	1	1,595.3					1	1,595.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								